

**ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД:
ЗҮҮН ХҮРЭЭ ДАШЧОЙЛИН ХИЙДИЙН ЖИШЭЭН ДЭЭР**

*Г.Мягмарсүрэн (Ph.D)
Бурханы шашин соёл судлалын хүрээлэн
Ц.Алтанхүү
Зүүн Хүрээ Дашчойлин хийд*

Түлхүүр үгс: Шашин шүтэх, эс шүтэх эрх, олон ургальч үзэл, төр, сүм хийдийн харилцаа, хууль эрх зүйн орчин, Дашчойлин хийд

Товч утга: Энэхүү илтгэлд Зүүн хүрээ Дашчойлон хийдийн жишээн дээр үндэслэн төр, сүм хийдийн харилцаанд тулгамдаж буй асуудлуудыг авч үзнэ.

* * * * *

Монгол Улсын иргэн нь 1992 оны 1 дүгээр сарын 13-ний өдөр зарлан тунхагласан Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн арван зургаадугаар зүйлийн 15-д "шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй" хэмээн заасан дагуу өөрийн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийн сүсэг бишрэлээр уламжлалт болон шинэ урсгал чиглэлийн шашин номыг чөлөөтэй сонгох эрхтэй болсон билээ.

Шашин шүтэх, эс шүтэх эрхээр өөрийн хүслээр шашнаа сонгох эрх чөлөөг ийн тунхагласан нь гадны олон шашны урсгал чиглэл Монголд чөлөөтэй нэвтрэн орж ирэх таатай нөхцөл бололцоог хангасан бөгөөд энэхүү үйл явц нь цөөн хүн амтай Монгол улсын хувьд чухам хэрэгтэй байсан эсэх, энэ нь чухам хэнд хэрэгтэй вэ, Монгол улсад амин чухал хэрэгтэй байсан уу зэрэг асуудлууд хөндөгдөж, улмаар олон нийтийн дунд яригдсаар өнөөг хүрчээ.

Олон шашны янз бүрийн үйл ажиллагаа, тэдгээрийн нийгэмд үзүүлэх үр нөлөөлөл, сүүлийн үед гарч буй асуудлууд, дэлхий дахинд ба монголд өрнөж буй шашны олон үйл явдал зэргээс ургуулан авч үзвэл шашин шүтэх эрх чөлөөний талаар нарийвчлан нухацтай авч үзэж, шийдвэртэй арга хэмжээ авах цаг болжээ.

Хэдийгээр энэхүү эрх чөлөө нь өнөөгийн олон улсын байдал, даяаршин буй нийгмийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлсэн ололттой талтай ч улс үндэстний нэгдмэл үзэл санаа, уламжлалт зан заншил, өв соёлоо хадгалан хамгаалах, хойч үедээ өвлүүлэн дамжуулахад сөрөг үр дагавар үзүүлж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Аливаа нэгэн улс үндэстний өвөрмөц онцлог нь тухайн улс үндэстний шашин шүтлэг, соёл уламжлал, зан заншил, амьдралын хэв маяг зэрэг олон хүчин зүйлээс бүрэлдэн тогтдог. Өнөө цагт дэлхийн олон улс орон нийгэм, эдийн засаг, соёл боловсрол даяарчлагдан, нэгэн нийтлэг болохын хамтаар өөрийн үндэстний онцлог, ёс уламжлал, зан заншил, өв соёлоо авч үлдэхийг басхүү эрмэлзэн, анхаарах болжээ.

Сүүлийн үед олон төрлийн шашин шүтлэг Монгол улсад нэвтрэн дэлгэрч, сүм хийд, шашны байгууллагаа байгуулж, номлогч, дагагч, итгэгчдийн тоо хэмжээнд ч өөрчлөлт орж, олон шашны үзэл номлол зэрэгцэн орших боллоо. Энэ байдлаас улбаалан шашин шүтлэгээр бие биенээ ялгаварлан гадуурхах, үл хүлээн зөвшөөрөх, хоорондоо тэмцэлдэх, дайсагналцах явдал түгээмэл үзэгдэх боллоо. Шашинтай холбоотой янз бүрийн асуудлуудаар далимдуулж, монголчуудын хооронд элдэв аргаар яс хаях, хагаралдуулж

хуваах, бие биенийг нь үзэн ядуулах, дургүйцлийг өдөөх зорилготой үйлдэл олон илрэх болжээ. Монголчуудын уламжлалт ёс заншил, оюун санаа, үзэл ухамсар, түүх соёлын эрхэм бүхнийг гутаан доромжлох хандлага их харагдах болов. Үүнээс шалтгаалан Монголчуудын эе эв эвдэрч, уламжлал түүх нь гуйвж, ёс заншилаасаа холдвол энэ нь хэнд ашигтай байх вэ, энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ зэргийг тун сайн бодолцож үзэх хэрэгтэй байна.

Хүн өөрт олгогдсон эрх, эрх чөлөөг эдлэхдээ бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, улс үндэснийхээ аюулгүй байдал, эв нэгдэл, ёс уламжлал, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй юм. Ийм учраас иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх, үүргийг нарийн тодорхойлсон, шашны дотоодын болон хоорондын харилцааг зохицуулсан, маш тодорхой хууль чухал хэрэгтэй байна.

Шашны харилцааг зохицуулах хууль эрх зүй

Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах, төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулах зорилгоор 1993 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр "Төр, сүм хийдийн харилцааны хууль"-ийг Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан билээ.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших 26 жилийн хугацаанд нийгмийн харилцааны хөгжлийн төлөв байдлаас шалтгаалан тус хуульд 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, тус хуулийн шинэчлэн найруулсан 2 төслийг холбогдох төрийн захиргааны байгууллагууд боловсруулан гаргажээ.

Ялангуяа төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулж ирсэн харилцааг төрөөс шашны талаар баримтлах бодлого, иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй байх эрхийн баталгааг хангахад чиглүүлэн "Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль" нэрээр 2018 онд ХЗДХЯ-наас шинэчилсэн боловсруулсан гэх хуулийн төсөл нь ихээхэн маргаан дагуулсан билээ.

"Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль"-ийг улам боловсронгуй болгож, улмаар сүм, хийд байгуулах зөвшөөрлийн тогтолцоог сайжруулж, хуулийн үндэслэл, журам, хэрэгжилтийг боловсронгуй болгож, дахин нэмэлт, өөрчлөлт оруулж, төр, шашны байгууллагын хоорондын ба шашин хоорондын харилцаа, үйл ажиллагаатай холбоотой тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд санаа болохуйц хэдэн санал дэвшүүлье.

- Хуулийг өөрчлөн, шинэчлэн найруулахдаа шашны байгууллагын төлөөллүүд, мэргэжсэн судлаачид, бусад төлөөллийг оролцуулан хэлэлцэн боловсруулах
- Төр сүм хийдийн харилцааны хууль нь цөөн хүн амтай улсад олон төрлийн үзэл бодол, шашин шүтлэг дэлгэрэхэд хязгаарлалт тавих, түүнийг хяналтандаа байлгах шаардлагатай
- Тус хуулийг шинэчлэн боловсруулахдаа аливаа шашны үндсэн суурь үзэл баримтал, онол сургаалыг зөрчсөн зүйл заалтыг оруулахгүй байх. Хуулиар шашны асуудлыг зохицуулах нэрийн доор аливаа шашныг алсдаа доройтуулах, улмаар мөхөөх нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх
- Төрөөс шашны талаар баримтлах бодлогыг тодорхойлоход шашны байгууллагад татварын болон бусад хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, шашны байгууллагын эзэмшилд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, хадгалах, сэргээн

засахад хөрөнгийн болон бусад туслалцаа үзүүлэх зэргээр төрөөс шашны байгууллагыг дэмжих, хамтран ажиллах хэлбэрийг тогтоох

- Өнөөдөр таван монгол хүн тутмын гурав нь ямар нэгэн шашин шүтдэг бөгөөд тэдгээрийн талаас илүү хувь нь уламжлалт Буддын шашныг шүтэж байгаа нь судалгаагаар нэгэнт тогтоогдсон байгаа тул Монгол улсын төрт ёс, үндэсний эв нэгдэл, уламжлал заншил, түүх соёлыг нандигнан өвлөх, өвлүүлэх үүднээс уламжлалт Буддын шашны зонхилох байр суурийг тодотгосон зүйл заалт нэлээд тодорхой оруулах
- Шашин ухуулан дэлгэрүүлэхэд нөгөө шашны нэр хүнд, үйл ажиллагаа, хэрэгт шууд ба шууд бусаар хандсан эсрэг аливаа ухуулга сурталчилгаа зэргийг ашиглахыг хориглох хэрэгтэй гэсэн утга бүхий зүйлт нэмж оруулах
- Монгол үндэстний өв соёл, уламжлал заншилд шууд ба шууд бусаар харшлах бол гадны шинэ шашны аливаа зан үйлийг шууд импортлон оруулж, улмаар үзэл баримтлалаа түгээхийг хориглоно гэх утгатай хуулийн зүйл заалт нэмж оруулах
- Энэ хуулиар шашны байгууллага байгуулах зөвшөөрөл олгох зэрэг асуудал нь зөвхөн шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн ажлын хүрээнд шийдэгдэх болох тул шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах орон нутгын төрийн байгууллага, шашны байгууллага хоорондын харилцаа ямар түвшинд явагдахыг тодорхойлох
- Цаашид сүм хийдийн өмч нь нийтийн өмч байх талаар хуульчлан батлах нь зохимжтой. Хэдийгээр хувь хүн сүм хийд байгуулж болох ч байгуулсны дараа сүм хийдийн өмч нь нийтийн өмч байх шашны үндсэн суурь үзэл баримтал, онол сургаалд нийцэнэ. Сүм хийд нь олон нийтийн тусад үйл ажиллагаа явуулдаг байгууллага учир амьжиргааны эх үүсвэр, хөрөнгөжих, ашиг олох хэрэгсэл болгож болохгүй.

Энд нэг зүйлийг онцлон дурдахад статистикийн мэдээгээр гадны шинэ шашны сүм, байгууллагын тоо сүүлийн хэдхэн жилд эрс нэмэгдсэн байгаа нь сонирхол татсан асуудал бөгөөд зөвхөн арваад хүн нэгдээд л шашны бүлэг, байгууллага байгуулж болохоор байгаа тул дээрх статистикийн тоо баримт бодитой үнэн зөв гарах эсэхэд нөлөөлж болохоор харагдаж байна. Үүнээс үүдэн бодит бус статистик тоо баримт гаргаж, улмаар гадны шинэ шашин хөгжиж дэлгэрч байна гэсэн нэг талын ухуулга сурталчилгааны ажил гэж үзэж байна.

Төр, сүм хийдийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд

Хэдийгээр хүн амны дийлэх олонх шүтдэг, түүх соёл, ёс заншил зэргийн хувьд баялаг өв уламжлалтай ч шинэ тулгар байгуулагдсан бурхны шашны сүм хийдүүд нь бусад шашны байгууллагын нэгэн адил энэхүү нийгэм, улс төр, эдийн засгийн хурдацтай өөрчлөлт дунд оршин тогтнох, үйл ажиллагаагаа тогтмол явуулах зэрэгт тулгамдаж буй олон асуудал байна. Төр, сүм хийдийн харилцаанд тулгарч буй эдгээр асуудлыг хуулийн хүрээнд хэрхэн зохицуулж шийдэх болох талаар Зүүн Хүрээ Дашчойлин хийдийн жишээн дээр авч үзье.

1. Төрөөс түүхийн дурсгалт соёлын өвд бүртгэгдсэн сүм хийдийн барилга байгууламжийг хадгалах, хамгаалах, засварлах талаар соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу шийдвэртэй ажиллах нь нэн тулгамдсан асуудал болж байна. Зүүн Хүрээ Дашчойлин хийд нь гэр хэлбэрт модон дуганд үйл ажиллагаа

явуулдаг. Энэхүү гэр хэлбэрт модон дуганууд нь Монголын үндэсний архитектурын дурсгалын нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Одоогийн Улаанбаатар хот буюу хуучнаар Их Хүрээний барилга байгууламжаас үлдсэн цөөхөн архитектурын дурсгалын нэгээхэн хэсэг нь Зүүн Хүрээний 30 аймгаас хадгалагдан үлдсэн гурван дуган болно.

Нэг. Эрхэм тойны аймаг нь 1737 онд байгуулагдаж, одоогийн дуганы модон барилга нь 1778 онд баригджээ. Одоо Дашчойлин хийдийн сахиусны дуган болно.

Хоёр. Вангай аймаг нь 1757 онд байгуулагдаж, одоогийн модон дуганы барилга нь 1790 оны орчим баригджээ. Одоо энэ дуганд Дашчойлин хийдийн Цогчэн хурал өдөр бүр хурж байна.

Гурав. Их хүрээний сүүлчийн 30 дахь аймгийг дуганы хамт 1903 онд VIII Богд Жавзандамба хутагтын зарлигаар Эх дагина Дондовдулам хатан анхлан байгуулсан учир Эх дагины аймаг хэмээн нэрлэжээ. Эх дагины дуганыг 1940 онд зураач Л.Намхайцэрэнгийн зураг төсөл, удирдлагын дагуу циркийн зориулалтаар өөрчлөн засварлаж, түүнээс хойш 2015 онд хүртэл Ж.Раднаабазарын нэрэмжит цирк байрлаж байв.

Вангай, Эрхэм тойн, Эх дагины аймгийн дуганыг анх БНМАУ-ын СнЗ-ын 1971 оны 12-р сарын 28-ны өдрийн 420-р тогтоолоор улсын хамгаалалтад авч, Монгол Улсын түүх, соёлын дурсгалт газрын жагсаалтад бүртгэсэн бол хамгийн сүүлд Засгийн газрын 1998 оны 235 дугаар тогтоолоор "Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д бүртгэн баталгаажуулжээ.

Зүүн Хүрээний хамгийн сүүлд байгуулагдсан хурал номын газар хэмээх утгаар Зүүн Хүрээ Дашчойлин хийдээс Эх дагины дуганы талаар олон удаа холбогдох яаманд хандаад өнөөг болтол шийдвэртэй арга хэмжээ аваагүй байсаар байна.

2. Түүхэн уламжлалт хийдийн үйл ажиллагааны зөвшөөрлийн сунгалтыг бусдаас ялгамжаатайгаар авч үзэх, илүү урт хугацаагаар сунгалтыг хийх, ер нь бүртгэл сунгалтын ажлыг илүү боловсронгуй болгох шаардлагатай.
3. Түүхийн дурсгалт соёлын өвд бүртгэгдсэн сүм хийдийн газрын татварын хөнгөлөлтийн талаар нягтлан үзэх, хамгаалалтын бүсийн талаар шийдвэртэй арга хэмжээ авах хэрэгтэй байна. Засгийн газрын 2001 оны 04 сарын 25-ны өдрийн 96-р тогтоолоор дээрх гурван дуганыг хамруулсан гэр хэлбэрт модон дуган буюу Дашчойлин хийдийн хамгаалалтын бүсийг 1.7 га газар байхаар тогтоосон ч түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүрэн бүтэн байдалд нөлөөлөхүйц үйл ажиллагаа явагдсаар байна.
4. Шашны боловсрол олгох асуудал хуулийн хүрээнд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөх асуудал тодорхойгүй бүрхэг байна. Шашны боловсрол олгох үйл ажиллагаанд тавигдах шаардлага, нөхцөлийг тодорхой заах, шашны сургуулийн тусгай зөвшөөрлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна. Өнөөгийн хууль эрх зүйн орчин нь шашны уламжлалт сургалттай сургууль байгуулах, залуу хойч үеийн лам нарыг сургаж бэлтгэхэд ихээхэн хүндрэлтэй байдлыг бий болгож байна. Ялангуяа шашны уламжлалт

сургалттай дунд сургууль ажиллуулах хууль эрх зүйн орчныг хаасан нь лам хуврагийн тоог хязгаарлах нэг ёсны хаалт болж байгаа юм.

5. Түүхэн уламжлалт хийдийг аялал жуулчлалтай холбож, тусгай сонирхолын аялал жуулчлал хийх боломжийг бий болгон Монгол уламжлалт соёл, урлал, сүм дуган гадаад дотоодын судлаач сонирхогчидод таниулахад холбогдох төрийн байгууллагууд хамтран ажиллахдаа дутмаг байна.

НОМ ЗҮЙ

1. Нацагийн Багабанди. Шинэ зуун: Даяаршин дангааршиж, дангааршин даяаршихын учир. Улаанбаатар 2004
2. М.Батаа. Буддын сүм хийдийн үйл ажиллагаа. Улаанбаатар 2017
3. Боловсролын тухай хууль. <https://www.legalinfo.mn/law/details/9020>
4. Их Хүрээний гучин аймаг. Баримт бичгийн эмхэтгэл 1651-1938 он. Зүүн Хүрээ Дашчойлин хийд. Монгол Улсын Их сургуулийн Түүхийн тэнхим. Улаанбаатар 2015
5. Монгол Улсын Үндсэн хууль. <https://www.legalinfo.mn/law/details/367>
6. Г.Мягмарсүрэн. Зүүн Хүрээ: Түүхэн уламжлал. Улаанбаатар 2015
7. Г.Мягмарсүрэн. Өлзий номын хийд. Улаанбаатар 2010
8. Олон улсын шашны эрх чөлөөний тайлан–Монгол Улс 2017. <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2017-international-religious-freedom-report-mn/>
9. Олон улсын шашны эрх чөлөөний тайлан–Монгол улс 2018. <https://mn.usembassy.gov/2018-international-religious-freedom-report-mn/>
10. Соёлын өвийг хамгаалах тухай хууль. <https://www.legalinfo.mn/law/details/10439>
11. Төр, сүм хийдийн харилцааны хууль. <https://www.legalinfo.mn/law/details/485>
12. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал. <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2018/10/Shashin-huuliin-uzel-barimtlal.pdf>
13. Шашин соёл судлал. Боть I. "Зүүн Хүрээ" Дашчойлин хийд. Бурханы шашин соёл судлалын хүрээлэн. Улаанбаатар 2018
14. “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” хуулийн төслийн тухай танилцуулга. <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2018/10/Shashin-huuliin-Taniltsuulga.pdf>
15. Шашны эрх чөлөө болон олон ургалч үзэл: Америк, Монголын хамтын үнэт зүйл. <http://www.tusgal.mn/shashnii-erkh-chuluu-bolon-olon-urgalch-uzel-amerik-mongoliiin-khamtiin-unet-zuil>

ABSTRACT

By the freedom of religious belief which ensured by the Constitution of 1992, Mongolian citizens possess to express freely their beliefs and aspirations. Despite it gives the opportunity to combine with condition of international status and more globalized social development, but it cannot be deniable that it produces the negative impacts on the unity of nations, protection,

promotion and preservation of national heritage and culture. Although based on massive inheritance, Buddhist monasteries, which are newly built, have many issues, like those of other faiths, to deal with the rapid and sustained changes of social, political and economic conditions. These issues are will be discussed in the article, focusing with the example of the Zuun Khuree Dashichoiling monastery, how to deal within the law.